## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 28-ны өдөр Дугаар БА-092/2025 Улаанбаатар хот

### Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 37 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 9 давхар 2 блок, 31 (гучин нэг) автомашины дулаан зогсоолтой, 144 (нэг зуун дөчин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

### Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/11/13 огноо, БАЗГ2023/912, 0014137 дугаар;

2.2.Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: А-10/2022;

2.3.Захиалагч: Батхэрэйд ХХК оноосон нэр, 9011080077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2680742 регистрийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, цагдаагийн академийн өргөн чөлөө, 82б, 22 тоот, 99092220 холбоо барих утас, Batkhereid2002@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.4.Барилгын ажлын гүйцэтгэгч: Батхэрэйд ХХК оноосон нэр, 9011080077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2680742 регистрийн дугаар, БУ12-739/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, цагдаагийн академийн өргөн чөлөө, 82б, 22 тоот, 99092220 холбоо барих утас, Batkhereid2002@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.5.Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Би Эл Ти бриллиант ХХК оноосон нэр, 9019030037 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5153034 регистрийн дугаар, ӨБ16-693/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 6 дугаар хороолол, 58, 49, 50, 51, 52 тоот, 99057821, 99055617 холбоо барих утас, Bltelevator@yahoo.com цахим шуудангийн хаяг;

Дөрвөн ээс инженеринг ХХК оноосон нэр, 9011728036 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6277799 регистрийн дугаар, 2225/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 25 дугаар хороо, хайрхан 2, 108 тоот, 98109787 холбоо барих утас, tsolmontumur3@gmail.com цахим шуудангийн хаяг;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Жанжин өргөө ХХК оноосон нэр, 9011183120 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5287987 регистрийн дугаар, БУ16-212/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 5 дугаар хороолол, 2-08 тоот, 99081472 холбоо барих утас, finance@janjinurgoo.mn цахим хаяг;

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Мөнх-Инж констракшн ХХК оноосон нэр, 9011342038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2819236 регистрийн дугаар, ЗТ12-217/22 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 204 тоот, 99999955 холбоо барих утас, mik.barilga@gmail.com цахим хаяг;

Армонде ХХК оноосон нэр, 9011007054 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5013208 регистрийн дугаар, ЗТ16-453/22 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Асгат, Жаргалант, 1-р байрны 32 тоот, 91003338 холбоо барих утас, infoarmonde@gmail.com цахим хаяг;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Батхэрэйд ХХК оноосон нэр, 2680742 регистрийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, цагдаагийн академийн өргөн чөлөө, 82б, 22 тоот, 99092220 холбоо барих утас, Batkhereid2002@gmail.com цахим хаяг;

Орон Сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 17 оноосон нэр, 2117118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Их Тойруу, Өөрийн байр, 88922080 холбоо барих утас, info@osnaaug.ub.gov.mn цахим хаяг;

2.8.Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

## Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1.Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 9 давхар 2 блок, 31 (гучин нэг) автомашины дулаан зогсоолтой, 144 (нэг зуун дөчин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3.Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4.Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1.Дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 9 давхар 2 блок, 31 (гучин нэг) автомашины дулаан зогсоолтой, 144 (нэг зуун дөчин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Батхэрэйд ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 2 блок, 31 (гучин нэг) автомашины дулаан зогсоолтой, 144 (нэг зуун дөчин дөрөв) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Батхэрэйд ХХК-ийн захирал (Д.Байгалмаа)

## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 37 ДУГААР ХОРОО, БАТХЭРЭЙД ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 9 ДАВХАР 2 БЛОК, 31 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 144 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 26 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Батхэрэйд ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 2 блок, 31 автомашины дулаан зогсоолтой, 144 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхарт 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:30 цагт дуусав.

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: Батхэрэйд ХХК-ийн захирал | Д.Байгалмаа |
| 3 | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 4 | Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер | Б.Цэрэннадмид |
| 6 | Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчдийн холболтын ахлах инженер | Б.Оргил |
| 7 | Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Ө.Шинэцэцэг |
| 8 | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Ц.Дагвадорж |
| 9 | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх тасгийн дэд хурандаа | М.Батсайхан |
| 10 | Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэс, мэргэжилтэн | Б.Жаргал |
| 11 | Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 12 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төв-17-ын дарга | Л.Намжилмаа |
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Н.Эрдэнэтөгс |
| 14 | Зураг төслийн Мөнх-Инж констракшн ХХК-ийн захирал | Л.Мөнхсайхан |

| | | |
|---|---|---|
| 15 | Гүйцэтгэгч Батхэрэйд ХХК-ийн захирал | Д.Байгалмаа |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Батхэрэйд ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 2 блок, 31 автомашины дулаан зогсоолтой, 144 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийн 2, 3, 4 дүгээр хүснэгтийг бичээгүйг гүйцээж, ажил хүлээн авсан ил далд ажлыг баталгаажуулсан материалын чанар нэр төрлийг тэмдэглэж дахин хянуулах
- Бетон арматурын шинжилгээ, ил далд ажлын акт зохиогч захиалагчийн дүгнэлтийг хянуулах. Парпетны малгайвч хийж гүйцэтгэсэн фото зураг ирүүлэх, дээвэрт гарах хаалганы зураг үзүүлж, ашиглалтын аюулгүй байдлыг хангуулж, гүйцэтгэлийн хариу ирүүлж хянуулах
- Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу хяналтын газраас өгсөн шаардлагын биелэлт хангагдсан эсэхийг хянуулж хариу өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулааны худагт байрлах шугам будаж дулаалах, цэвэрлэх
- Урд орцны халаах хэрэгсэлд термостат угсрах
- Халуун, хүйтэн усны коллектор дотор байрлах шугамуудад бэхэлгээ, хаягжуулалт хийх
- Шугам сүлжээний актуудыг батлагдсан загварын дагуу баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- Гадна болон дотор цахилгааны угсралтыг гүйцэтгэсэн актад захиалагч, гүйцэтгэгч нар гарын үсэг зурж баталгаажуулах
- Газардуулгын эсэргүүцэл хэмжүүлж протокол, тамга тэмдгээр баталгаажсан хувийг шалгуулах

- Барилгын төмөр хашаан дээр байрлуулсан цахилгааны түр тэжээл самбарыг хураах, аюулгүй байдлыг хангуулах
- Гадна цахилгааны 0,4кВ-ын ЦДКШ-г мэдээллийн санд оруулсан акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчдийн холболтын албаны ахлах инженер **Б.Оргил:**

- Холигч узелийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ хаягжуулалт хийж, дулаалга чанарын шаардлага хангасан хомутаар тогтоох
- Дотор систем термостат вентиав гүйцээж угсрах
- Гадна худагт дулаалгын шаардлага хангасан, механик үйлчлэлд тэсвэртэй бүрхүүлээр бүрэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Ө.Шинэцэцэг:**

- Ус сувгийн удирдах газраас олгосон 692/23 тоот техникийн нөхцөлд заагдсан ус нөөцлөх савыг угсрах
- Дээрх техникийн нөхцөлийн дагуу гадна цэвэр усны шугамд галын гидрант суурилуулах
- Цэвэр усны шинжилгээ өгөх
- Гадна цэвэр, бохир усны актыг стандартын дагуу баталгаажуулах
- Бохир усны худагт дулаалга модон таг хийх
- БУХ төв шугамд нийлж байгаа хэсэгт шугамын трап дээр гүйцэт унагаж холбох
- Цаашид зургийн автор болон гүйцэтгэгчид ус хангамжийн гадна системд фланцат хаалт суурилуулж аваарын байдалд бэлтгэх
- Цэвэр усны дутуу шугамыг гүйцээж дулаалга худгийг цэвэрлэх
- Хөрс борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх
- Гүйцэтгэлийн зураг CD, акт нэг хувийг Ус сувгийн удирдах газарт өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Хяналтын камер бүрэн ажиллуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх тасгийн дэд хурандаа **М.Батсайхан:**

- Барилгын гадна хананы дулаалга материалын гал тэсвэршилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Зоорийн давхрын цахилгаан шатны өмнөх хаалтыг норм дүрэмд нийцүүлэх, тайлбар өгөх
- Гал унтраах автомат спринклерийн системийн төгсгөлд манометр хийж туршиж шалгаад видео бичлэгээр баримтжуулах

ЛАЛТ ША
ГАЗ
айгуулам
оруулах

- Галын дотор усны даралтат цэг ГК-г даралттай усаар хангах
- Галын дохиолол мэдээлэгч гүйцээж хийх
- Гадна гидрант хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **Б.Жаргал:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын сангийн төлбөрийг тооцуулж, төлөх
- Барилгын цонхны онгойлтыг зураг төслийн дагуу хийх
- Есөн давхрын хаяавчны дээд хэсгийн усны хаялгыг үргэлжлүүлэх
- Өрөө тасалгаанд агаарын орчны шинжилгээ хийлгэх
- Парпедны төмөр малгайг 0.8мм-с багагүй зузаан гөлмөн төмрөөр хийх
- Цонхнуудад хүүхэд унахаас хамгаалах тор хийх
- Барилгын ил далд ажлын актыг нөхөн шалгуулах
- Лифтний хонгилтой давхцаж байгаа айлын хананд дуу тусгаарлалт хийснийг шалгуулах
- Барилгын материалын гарал үүсэл, тохирлын гэрчилгээний баримт бичгийг шалгуулах
- Тагтны төмөр хашлага хийснийг босоо шилбэтэй болгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Архивд баримт бичиг хүлээлгэж өгөх нийтлэг жагсаалтын баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх
- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, талбайн журналыг баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төв-17-ын дарга ***Л.Намжилмаа:***

- Бохирын гаргалгаанд (худаг) үл буцаах клапан суурилуулах
- Шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж ХҮТ-17-д байраа хүлээлгэж өгөх
- Айл өрхүүдийн халаалтын регистр дээр термостат хаалт гүйцээж суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс:**

- Гадна авто зогсоолд, явган хүний зам талбайд машины дугуй цохигч буюу хязгаарлагч хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ЛГАЛТЫ
Р
ийг ашигл
комисс

Зураг төслийн Мөнх-Инж констракшн ХХК-ийн захирал **Л.Мөнхсайхан:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна

Барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгч Батхэрэйд ХХК-ийн захирал **Д.Байгалмаа:**

- Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Зохиогчийн дүгнэлт шинэчлэн ирүүлэх
- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Батхэрэйд ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 2 блок, 31 автомашины дулаан зогсоолтой, 144 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Батхэрэйд ХХК-ийн захирал (Д.Байгалмаа)